



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/58.

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг зохион
байгуулж явуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2023 оны 51 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 319 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй амины орон сууцны зориулалттай дуусаагүй барилгыг худалдах нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулж явуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч,
Төрийн өмчийн төлөөлөгч:

Д.Одмаа-Төрийн өмчийн удирдлага,
зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Дуудлагын худалдааны хөтлөгч:

М.Баярмаа-Төрийн өмчийн бүртгэл,
ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Дуудлагын худалдааны тэмдэглэл
хөтлөгч:

Д.Дариймаа -Төрийн өмчийн удирдлага,
зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж явуулахыг Ажлын хэсэг /Д.Одмаа/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

133013628

ТӨБЗГ тушаал-/2023